

Түүх 8 :
Сайн санаат Самари хүн

Библийн эшлэл
[Лук 10:37]

тэр – Түүнд энэрлийг үйлдсэн нь гэв. Есүс түүнд – Явж,
үүний адил үйлдэгтүн гэжээ.

Нэгэн Хуульч Есүсийг шалгахаар ингэж асуув. “Мөнх амийг өвлөн авахын тулд би яах ёстой вэ?”

Есүс түүнд, Хуульд юу гэж бичигдсэн байдаг билээ?

Хуульч Түүнд ингэж хариулав.

“Чи Эзэн Бурханаа бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч, бүх оюун ухаанаараа хайрла. Мөн хөршөө өөрийн адил хайрла.” гэж хэлсэн байдаг.

Хуульчийг ингэж хариулсны дараа Есүс ингэж хэлэв.

“Чи зөв хэллээ. Хэлснийхээ дагуу амьдарвал мөнх амийг олох болно.” гэж хэлэв.

Харин хуульч өөрийгөө зөвтгөх гэж Есүсээс ийнхүү асуув. “Тэгвэл миний хөрш гэдэг чинь хэн бэ?”

Хариуд нь Есүс түүнд нэгэн сургаалт зүйрлэлийг ярьж өгөв.

Нэгэн хүн Иерусалимаас Иерихо орохоор явж байгаад дээрэмчидтэй таарчхаж гэнэ.

Дээрэмчид түүнийг нүцгэлэн зодоод амьтай төдий орхиод оджээ.

Тэр хүн маш хүнд бэртсэн тул босох ч тэнхэлгүй болсон байв.

Гэтэл тэр үед хаанаас ч юм хөлийн чимээ сонстов.

Тэр хөлийн чимээ бол сүм дотор Бурханд тахил өргөдөг тахилч байлаа.

Гэвч тахилч, газарт хүн хэвтэж байгааг харсан хэдий ч хараагүй юм шиг дэргэдүүр нь өнгөрөөд явчхав.


Хэсэг хугацааны дараа хэн нэгний ирж байгаа хөлийн чимээ дахиад сонсогдов.

Тэр бол сүмийн тахилчид тусалдаг Леви хүн байлаа.

Леви хүн ч бас газар хэвтэж буй залууг харсан ч хараагүй мэт дүр эсгэж өнгөрөөд явчихжээ.

Зодуулаад шархадсан залуу газраас өндийх тэнхэлгүй бие нь улам л суларч байв.





Гэтэл хэсэг хугацаа өнгөрсний дараа дахин хэн нэгний ирж буй хөлийн чимээ сонсогдож эхлэв.

Нэгэн илжиг унасан хүн байв. Тэр хүн бол Самари хүн байв. Гэвч Израилчууд Самари хүнд ихэд дургүй төдийгүй тэднийг үл тоомсорлодог байв.

Газар хэвтэж байсан залуу хамаг бие нь сүльдаж бараг бууж өгч байлаа.

Гэтэл гайхалтай зүйл болов.

Өнөөх Самари хүн шууд илжигнээсээ бууж ирээд дээрэмчдэд зодуулсан залуу руу очив.

Самари хүн, эхлээд тэр залуугийн цусыг болгоомжтой цэвэрлэж өгөв.

Самари хүн бас тэр залуугийн шарханд нь эм түрхэж шархыг нь сайтар боож өгөв.

Самари хүн, өнөөх залууг илжгэн дээрээ суулгаад дэн буудалд аваачин бүтэн өдрийн турш хамт байж түүнийг асрав.

Маргааш нь Самари хүн дэн буудлын эзэнд мөнгө өгөөд ингэж хэлэв.

“Би одоо явах хэрэгтэй болчихлоо. Шархадсан залууг сайн асарч байгаарай.

Та илүүг зарвал би буцахдаа танд дахин төлье” гэж хэлэв.

Есүс энэхүү урт түүхийг ярьж дуусгаад Өөрөөс нь асуулт тавьсан хуульчаас ингэж асуув.

“За, тэгэхлээр энэхүү сургаалт зүйрлэлд гурван төрлийн хүн гарсан. Тахилч, Леви хүн, Самари хүн.

Тэд дундаас хэн нь дээрэмчдэд зодуулсан залуугийн сайн хөрш нь байсан бэ?”

Хуульч ингэж хариулав.

Зодуулж шархадсан хүнд тусалсан сайн санаат Самари хүн билээ.

Есүс ингэж хэлэв.

“Тийм ээ, чиний зөв. Чи ч бас явж Самари хүнтэй адил хайрыг бусадтай хуваалцан амьдраарай” гэв.

- Дараах библийн эшлэлийг дуурайж бичээд цээжлээрэй. (Лук 10:37)

Есүс түүнд – Явж, үүний адил үйлдэгтүн гэжээ.

Бүтээлч байцгаая 1. Дээрэмчдийн халдлагад өртсөн хүнийг эмчлэхэд бас сэргээхэд хэрэгтэй зүйлсийг дугуйлаарай.



Бүтээлч байцгаая 2. Өнөөдөр юу сурснаа сайн бодонгоо өнгөөр ялгаж будаарай.

